



“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН 2025 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юу Эй Эф Ассет Менежмент ХХК
(Хөрөнгө итгэмжлэн удирдагч)
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/,
Олимпийн гудамж, 7/2 байр, 803 тоот
Утас: +976-70122346

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

А.Батболд /"Омни Ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/

Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл	6

1. ХБҮЦ-ны мэдээлэл

"Омни Ассет ТЗК" ХХК нь 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Омни Капитал ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Омни Ассет ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар А.Батболд, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр М.Мягмарсүрэн, ТУЗ-ийн хараат гишүүнээр С.Нина нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК ажиллаж байна.

"Омни Ассет ТЗК" ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 6.0 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Омни Ассет ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011851823
Регистрийн дугаар	8356327
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2023/11/08
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	552
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	50,000
ХБҮЦ (ширхэг)	60,000
ХБҮЦ (сая төг.)	3,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	19.6%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь 2025 оны эхний хагас жилд ХБҮЦ-ны хүүгийн төлбөрт 293.19 сая төгрөгийг хуваарийн дагуу төлсөн байна. ХБҮЦ-ны үлдэгдэл хугацаанд Хүснэгт 2-т харуулсан төлбөрийг төлнө.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үлдэгдэл
1	2025/08/28	-	148,208,219.18	3,000,000,000.00
2	2025/11/27	3,000,000,000.00	146,597,260.27	-
Нийт		3,000,000,000.00	294,805,479.45	-

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

2025 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 2024 оны эцсийн үлдэгдлээс 9.89 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2024.12.31	2025.06.30	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	2,899,114,886.82	3,185,952,423.22	9.89%
Зээлийн дундаж үлдэгдэл	14,142,023.84	17,221,364.45	21.77%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	1.23%	2.44%	1.21%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	10.95%	16.58%	5.63%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	35.91%	35.62%	-0.29%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	54.66%	60.15%	5.49%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	12.48	11.06	-11.38%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	27.20	36.50	34.20%
Сарын дундаж төлбөрийн дүн	989,459.25	1,024,019.72	3.49%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	4,438,518.13	4,103,518.57	-7.55%
Зээлийн тоо	205	185	-9.76%
Зээлдэгчийн төрөл	Иргэн	Иргэн	-
Барьцаа хөрөнгийн үнэлгээ /нийт/	6,327,970,000.00	6,185,640,000.00	-2.25%
Үл хөдлөх	210,200,000.00	140,000,000.00	-33.40%
Автомашин	6,117,770,000.00	6,045,640,000.00	-1.18%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	1.23%	1.23%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр)	7,394,400,372.88	9,235,743,248.75*	
Зээлийн үндсэн төлбөр	5,386,220,928.42	6,672,123,766.11	
Хүүгийн төлбөр	2,005,226,225.00	2,560,080,533.56	
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	2,953,219.46	3,538,949.08	

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2025 оны 6 дугаар сарын эргэн төлөлт болох 273.92 сая төгрөгийг гэрээний дагуу 2025 оны 7 дугаар сарын 05-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Омни Ассет ТЗК" ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ХБҮЦ-ны төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 26.69 сая төгрөг, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 8.2 хувь, харилцах дансны үлдэгдэл 524.7 мянган төгрөг байна.

Тайлант хугацаанд "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК нь "Омни Ассет ТЗК" ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	71	-
2	Хугацаа хэтэрсэн тул буцаан шилжүүлсэн	5	88,125,330.73
3	Багцад нэмж бүртгэсэн	56	1,660,865,704.82
Нийт		132	1,748,991,035.55

3. Төлөөлөн удирдах зөвлөл

"Омни Ассет ТЗК" ХХК-ийг "Омни Капитал ББСБ" ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч "Омни Капитал ББСБ" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ("Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭХ-23/003 тоот шийдвэрээр А.Батболд, С.Нина, Х.Хэрлэн нарыг ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн А.Батболдыг ТУЗ-ийн даргаар томилсон.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Хэрлэнгийн хүсэлтийн дагуу 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭХ-23/004 тоот шийдвэрээр ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, М.Мягмарсүрэнг ТУЗ-ийн гишүүнээр томиллоо.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 3 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2025.01.09	Тайлан батлах тухай Гүйлгээ хийх эрх олгох тухай	2024 оны 4 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн. Компанийн 1 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлыг төсвийг баталж, гүйлгээ хийх эрхийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид олгов
2	2025.04.09	Тайлан батлах тухай Гүйлгээ хийх эрх олгох тухай	2025 оны 1 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн. Компанийн 2 дугаар улирлын үйл ажиллагааны зардлыг төсвийг баталж, гүйлгээ хийх эрхийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид олгов
3	2025.04.28	2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хүлээн зөвшөөрөх тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай	2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг баталж СЗХ, МХБ-д хүргүүлэв. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж, 2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулж, батлуулав.